

ГОВИЙН МАЛЧДЫН ЗУДНЫ ЭРСДЛИЙН ТУХАЙ САНАЛ: МАЛЧИД БОЛОН ЗАСГИЙН ГАЗАР ХОЁУЛАА ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ ЁСТОЙ

Анна Эриксэн

АНУ-ын Аризонагийн их сургуулийн Антропологийн ухааны докторант

Монголын хөдөө орон нутагт хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны ажилд тулгуурлан бичсэн энэхүү ажил нь социализмаас капитализмд шилжсэнээс хойш 20 гаруй жилийн дараах өнөөдөр малчид хариуцлага болон эрсдэлийн менежментийн талаар юу гэж бодож явдгийг авч үзлээ. Монгол малчид зуд хэмээх өвлийн байгалийн гамшгийн улмаас маш олон тооны малын хорогдлыг тогтмол амсдаг билээ. Зуд гэдэг нь мал сүрэгт аюул гамшиг учруулдаг өвлийн цаг агаарын нөхцөл байдлыг заасан ерөнхий нэр томъёо юм. Зудын тодорхой төрлүүд нь, тухайлбал, хэт их цас орох, бэлчээр мөсөөр хучигдах, зун хур багатайгаас бэлчээрийн гарц муу байх, цочир хүйтрэх, тухайн газар нутагт бэлчээр булаацалдан өрсөлдөх гэх мэт хэлбэртэй байж болно. Мал сүрэг өвөлд өнтэй орохын тулд тарга тэвээрэг сайн, эрүүл байж, өвс тэжээлээр тогтмол хангагдах ёстой боловч тэжээл муудаж эхлэхэд хүйтэнд тэсэх чадвар нь доройтож улам эмзэг байдалтай болдог. Тийм учраас зудын улмаас мал хорогдох нь мал харангадаж, хөлдсөнөөс болж үхсэн гэж ерөнхийдөө ойлгогддог. Бэлчээрт гарах боломжгүй болсон улиралд малчид мал сүргээ эсэн мэнд авч үлдэхийн тулд хадлан өвс болон бусад нөөцийг базааж, мөн өвөлтөрлох газраа сонгож, салхинаас нөмөр газар хашаа саравч бэлддэг хэдий боловч зуд нь мал сүрэг төдийгүй малчдын амжиргаанд аюул заналхийлэл учруулсаар байна.

Монгол улс капитализмд шилжих үед малыг хувьчилсан нь малчдад мал сүргээ үржүүлж баялаг хуримтлуулах боломж олгохын сацуу зудын эрсдэлийг өөрийн хүчээр бие дааж аргалах гэсэн хүнд ачаа тэдэнд үүрүүлсэн юм. 1993оны зуд (Темплер болон бусад, 1993 он), 1999-2002оны зуд (Сиура ба Свивт, 2002 он) болон 2010 оны зудын (Стернберг, 2010 он) аймшигт үр нөлөөнөөс үзвэл зарим ажиглагчид малчид дээрх хариуцлагаа гүйцэтгэж чадахгүй байна гэж дүгнэсэн байдаг. Миний энэхүү судалгаа нь хот суурин газрын Монголчууд хоорондын болон олон улсын хөгжлийн нийгэмлэгийн олон нийтийн дараах ойлголт яриаг судлах хүсэлдээ хөтлөгдөн хийсэн ажил болно:

1. Малчид бүх юм сайн сайхан болно гэж найдаж, таамаглахаа урьтал болгон өвлийн улирлын эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн төлөө шаргуу ажилладаггүй.
2. Малчид социалист нийгмийн үед улсаас тусламж дэмжлэг хараад сурчихсан. Малчид хүнд хэцүү үед одоо ч гэсэн хэн нэгэн нь тусламжийн гараа сунгахыг хүлээж суудаг учраас өөрсдийн мал сүрэг, ахуй амьдрал, амжиргаагаа хамгаалахын тулд санаачлага гаргахдаа ядмаг.
3. Малчид эрсдлийн менежментийн эсрэг тэсрэг бодлогогүй сонголт хийдэг. Тухайлбал, сүргийн доторх малын чанарт бус тоонд илүү анхаарал хандуулдаг.

Малчдын талаарх иймэрхүү мэдэгдэл нь тэднийг залхуу, хариуцлагагүй, бодлогогүй гэсэн утга санааг илэрхийлж байна. Эдгээр нь наад зах нь хэтрүүлэг, эсвэл малчдын талаарх буруу ташаа ойлголт байж болох бөгөөд эрсдэлийг өөрсдийн хүчээр зүй зохистой удирдан хянах малчдын замд тээг болж буй эдийн засаг, улс төрийн хүчин зүйлээс бусдын анхаарлыг холдуулж байгаа юм. Баруунд ч (жишээ нь, нийгмийн халамжийн тухай маргаанд), олон улсын хөгжлийн сэдвээр хэлэлцэж байхад ч, “залхуу” ба “хариуцлагагүй байх” гэсэн ойлголт нь нео-либерал үзлээс гаралтай бөгөөд энэ үзлээр бол хувь хүн өөрт тохиолдсон эрсдэлийг удирдан хянаж, улмаар өсч дэвжих байгалаас заяасан боломжтой гэж үздэг. Социализмаас капитализмд шилжих үеийн Монгол шиг хувь хүнд бизнес эрхлэх эрх чөлөө олгоод байхад, хувь хүн өсч дэвжих, уян хатан байх амжиргаагаа баталгаатай байлгаж чадахгүй бол, тэд санаачлага гаргаж, шаргуу ажиллаж чадахгүй байна гэж үзэх болно. Монгол улс капитализмд шилжсэнээс хойш одоог хүртэл Монгол дахь гадаадын зөвлөхүүд нео-либерал онолыг илт хөхиүлэн дэмжсээр байна. Энэ нь өнөөгийн хөгжлийн санаачлагууд нь малчдын ажлын ёс суртахуунаас гадна орон нутгийн зуданд өртөмтгий байдалд хүргэх хүчин зүйлийг тооцоолж үздэггүй гэсэн үг биш. Энэ эмзэг байдлыг ойлгож, бууруулах хүчин чармайлт гаргадаг хөгжлийн нийгэмлэгийн гишүүд энэ нь олон талт асуудал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хэдийгээр тийм боловч, энэхүү олон нийт болон баруунжсан Монголчуудын үзэж байгаа “малчид залхуу гэдэг ойлголт” нь миний бодлоор АНУ ба Европт байдаг нео-либерал үзэлтэй нягт уялдсан хохирогчдыг буруушаах сэтгэлгээг харуулж байна.

Орон нутаг дахь оролцогчдын ажиглалт, ярилцлага болон санал асуулга дээр тулгуурлан бичсэн энэхүү судалгааны ажил нь малчид эрсдэл ба хариуцлагын талаар юу гэж бодож явдгийг дүрслэн харуулна. Мөн малчид өөрсдөө малчид залхуу гэдэг ойлголтыг хэрхэн лавшруулж байгааг болон зудын эрсдэлийг удирдан хянах тал дээрх хувь хүний болон засгийн газрын үүрэг ролийн талаарх тэдний үзэл бодлыг авч үзнэ. Судалгааны ажлын үр дүнд “залхуу малчин” гэдэг яриа худал болохыг батлан засгийн газрын зүгээс үзүүлэх чухал хяналт, дэмжлэгийг оролцуулсан зудын эрсдэлийг удирдан хянах хамтарсан аргачлалыг боловсруулна.

Судалгаа хийсэн газрууд

Энэхүү судалгааны ажил нь Баянхонгор аймгийн өмнөд хэсэгт байрлах Говийн нэгэн суманд хийсэн угсаатны зүйн судалгаан дээр үндэслэгдсэн. Энд дурдсан хувь хүмүүсийн болон дараа дараагийн хэвлэн нийтлэх баримт бичгийн нууцлалыг хангах үүднээс сумын тодорхой нэрийг дурдаагүй болно. Монголын тал хээрийн бүстэй харьцуулахад говийн бүс өвлийн гүн цасанд дарагдах нь бага боловч зуны ган гачигт өртөмтгий бөгөөд ингэснээр өвөл мал сүрэг хүнд хэцүү байдалд ордог. Бас нэг бэрхшээлтэй тал нь говьд байгалийн хадлангийн талбай байхгүй. Хадлан бэлтгэх ажил нь Монголын хэвлэл мэдээлэл, засгийн газрын хувьд өвлийн бэлтгэлтэй агаар нэг боловч говийн малчдын хувьд тал

хээр, хангайн малчидтай харьцуулахад төдий их хэмжээний хадлан бэлтгэх боломж байхгүй. Түүний оронд тэд дор дурдах хэд хэдэн эрсдэлийн менежментийн стратегид найдахаас өөр арга байхгүй.



Судалгааны талбар болгон сонгосон сум нь гурван гол экологийн бүстэй бөгөөд эдгээр нь малчдын эрсдэлийн менежментийн стратегийг бүрдүүлж байна. Нэгдүгээрт, энэ бүсэд тогтсон уулын нуруу нь ялангуяа ямаа бэлчих, өвөл оторлоход тохиромжтой газар юм. Ямаа нь эгц налуу газар дээш доошоо хялбархан бэлчиж, тэдэнд тохирох өндөрлөг газар ургах бүдүүн, нарийн өвс идэн өвлийн хохир хатуун салхинаас хамгаалах уулын нөмөр газарт байгаагаараа давуу талтай. Бас нэг экологийн бүс нь хоолой гэгдэх цөлийн нам дор газар юм. Нөмөр газар байхгүй ч энэ нь нуруутай харьцуулахад хүйтний улирал, салхи шуурганд илүү эсэргүүцэл сайтай, цөлийн модон ургамлаар идээшдэг тэмээнд тохиромжтой. Эцэст нь голын ай сав газрын бүс буюу гол нь үхэр малд хамгийн тохиромжтой бөгөөд голгүй бол цөлийн бүсэд үхэр хэзээ ч идээшихгүй. Гол урсахгүй ч, энэ экологийн бүс нь харьцангуй өндөр, шигүү өвстэй учир жилдээ хэдэн сараар ч хамаагүй чөлөөтэй бэлчиж явдаг морь, үхэр зэрэг амьтдын таатай идээшлэх газар боловч тухайн газар нутагт амьдардаг малчин өрхүүдийн бэлчээрийн газраа хамгаалахад нь саад тотгор учруулдаг байна.

2010 оны эцэст хийсэн хүн, малын тооллогоор судалгаа хийсэн сум нийт 3500 оршин суугчидтайгаас хагас нь малчин бөгөөд ойролцоогоор 100,000 гаруй малтай гэжээ (хавар зудаар 40,000 мал хорогдсоныг тооцоод). Малын тоо тус бүрийг дор харуулав)

Төрөл зүйл	Нийт малын хувь	Тайлбар
Ямаа	72%	Ямаа бусад амьтдаас илүү хурдан үрждэг бөгөөд зудаас болж ямаан сүрэг цөөрсөн ч хурдан тоо нь өсдөг.

		Хэлбэлзэх боловч үргэлж өндөр үнэтэй байдаг ямааны ноолуурыг бодолцож үзвэл ямаа ихээхэн хэмжээний орлогын эх үүсвэр болдог.
Тэмээ	12%	Тэмээ үнэтэй, маллах болон арчлахад их хөдөлмөр шаардагддаг, удаан үрждэг бөгөөд говь нутагт тээврийн үүргийг мотоцикл орлон гүйцэтгэж байна. Эдгээрийг эс тооцвол, энэ нутагт амьдарч буй тэмээчид тэмээгээ маллан уламжлалаа даган амьдарч байна.
Хонь	14%	Хонь нь ямаатай адил ашигтай биш боловч хонины мах чухал тэмдэглэлт үед хэрэгтэй бөгөөд ноосоор нь хийсэн эсгийг гэр, гутал болон бусад зүйлд ашигладаг.
Морь	2%	Энэ нутаг дэвсгэрт морины тоо толгой олон байсан боловч зуд, ган болон цөлжилтөөс болж тоо толгой нь буурсан.
Үхэр	0.4%	Капитализмд шилжин малчдад улсаас үзүүлэх дэмжлэг байхгүй болсноос хойш байгалийн нөхцөл байдлын улмаас үхрийн тоо бас буурсан.

Монголын зарим нэг хуурайшилт багатай бүс нутгийн малчдыг эс тооцвол ихэнх малчид жинхэнэ нүүдэлчид байдаг. Ихэнх нь жил бүр эргэж очдог тогтсон өвөлжөөтэй боловч зун ган гачгаас болж тухайн өвөлжөөний бэлчээрийн чанар муудвал тэд өөр газар очиж өвөлждөг байна. Хавар нь малчид хаваржаа руу нүүх эсвэл өвөлжөөндөө үлддэг. Мал төллөх үе буюу 3-р сарын эхээр малчид шинэ төл, эх малд анхаарал тавин хэдэн сардаа нүүдэл зогсонги байдалд орно. Хавар ч гэсэн өвөлтэй адил зуд болох боломжтой, учир нь цаг агаар дулахан боловч бэлчээр болон хадгалсан өвс тэжээл (хадлан гэх мэт) багасч, мал эцэж туран, цас их хэмжээгээр орох нь эрсдэл дагуулсаар байдаг. 5-р сард ямааны ноолуур самнасны дараагаар малчин өрхүүд сая нэг нүүх завтай болдог.

Говьд зудын эрсдэлийг удирдан хянах нь

Хариуцлагын ухааныг авч үзэхийн өмнө өвлийн эрсдлийг давж туулах малчдын менежментэд шаардлагатай хийх ажил, стратегийн төрлүүдийг дурдах нь чухал. Малчид мал сүргээ зудаас амжилттай аврахад үеэс үед уламжилсан, мөн амьдрал дээр суралцсан шаргуу ажил, туршлагын хосолсон ухаан шаардлагатай байдаг гэдгийг тэд онцолдог. Зарим судлаач эрдэмтэд малчид удирдагчдаасаа ирсэн зарлиг, тушаалыг биелүүлдэг байсан учраас социализмын үед уламжилж ирсэн мэдлэгийн ихэнх нь алдагдсан гэж үздэг (Миернс, 1996 он). Гэсэн хэдий ч, уламжлалт мэдлэг, туршлагын үлэмж их хувь нь одоог хүртэл өвлөгдөж, эрсдэлийг даван туулах шинэ стратегиуд төрөн гарсаар байна. Дор эрсдэлийн менежментийн зарим ангиллыг дурдъя:

Өвс тэжээл: Зун, намрын улиралд малчин өрхүүд чадах чинээгээрээ ойр тойрны өвс тэжээлийг гараараа зулгаадаг. Гэвч зарим хүнд хэцүү жилүүдэд ихэнх малчид өвс тэжээл хурааж, чаддаггүй байна. Таана, хөмүүл зэрэг зарим ургамлыг сэвс, аарц зэрэгтэй холин зоодой болгон хатааж өвлийн улиралд малд

өгөх тэжээл болгодог. Малчин өрхүүд өөр олон төрлийн тэжээл, уух зүйлийг (бардаа) гараар бэлтгэн малдаа өгдөг байна.

Зах зээлд анхаарлаа хандуулах: Зарим хөгжлийн байгууллагууд малчдад маркетинг ба бизнесийн арга барилыг заахад анхаарлаа хандуулдаг. Ялангуяа малчдын ашиг орлогыг ихэсгэж, зарим нутаг дэвсгэрт хэт их ашигласнаас бэлчээр доройтож байгаа учраас мал сүргийн тоо болон бэлчээрийн даацыг бууруулах зорилгоор малчдад “тооноос илүү чанар” гэдэг ойлголтыг зааж сургадаг. Гэвч угсаатны зүйн нэгэн ажиглалт хөдөө орон нутагт амьдарч буй Монголчуудын дийлэнх нь бизнесийн ухаанд гаргууд сайн бөгөөд Хятад руу явж хямд бараа татаж эргэж ирээд зарах, эсвэл алт шигших зэргээр орлого олох өөр хувилбаруудыг тогтмол эрж хайдаг гэжээ. Түүнчлэн ихэнх хүмүүс гурилаас авахуулаад шатахуун хүртэлх бүх л зүйлийн үнийг сайтар судалж хянадаг байна. Миний хамт хоносон гэр бүлийнхэн дэлгүүр ороод ирэх болгонд авсан зүйлсийн үнийг асууж тодруулдаг байлаа. Намрын улиралд наймаачид тухайн нутаг дэвсгэрээр дайрч өнгөрөхдөө мал худалдан авч алслагдмал зайны зах зээлд наймаалахаар ирдэг байна. Наймаачид ирэх үеэр малаа хэдээр зарах вэ гэдэг нь хэн бүхний хаа сайгүй ярих сэдэв болно.

Нүүдэл ба нүүдлийн ухаан: Малчин өрхүүд мал сүргээ таргалуулж, өвөл ашиглах бэлчээрээ арчлахын хажуугаар зун, намрын турш ирэх өвлийн тухай бодож байдаг. Зун, намрын нүүдэл нь дараах хүчин зүйлээс хамааралтай:

- 1) Өвөлжөөний бэлчээр газрыг хадгалж үлдэх хэрэгцээ гарна, тийм учраас зун, намар нь өөр газар зуншиж, намаржина;
- 2) гэвч, зун цагт өөр малчид, мал сүрэг нүүдэллэн ирэхээс урьдчилан сэргийлж өвөлжөөгөө хааяа хааяа эргэн ирж буух хэрэгцээ гарна;
- 3) үргэлж хувьсан өөрчлөгдөх бороо хур, өвс дагах хэрэгцээ гарна.

Энэ нутаг дэвсгэрийн малчид цаг уурын өөрчлөлтөөс болж сүүлийн жилүүдэд ган гачиг ихэссэн гэх бөгөөд үүнээс болж тэд байнга нүүх хэрэгтэй болж, өвөлд бэлтгэх чадамж нь хязгаарлагддаг. Мөн ган гачгийн улмаас бороо хур сайн ордог газрын бэлчээрийг булаацалдах явдал их гарах болжээ. Монголын тал хээр газар нийтийн эзэмшлийн газар боловч бэлчээрийн газар ашиглалтыг зохих хэмжээгээр журамладаг. Өөр сумын газар нутагт малаа бэлчээх нь тэр сумын засаг захиргаанд татвар төлөх үндэс болдог. Сүүлийн жилүүдэд айл өрхүүд өвөлжөөгөө хууль ёсоор эзэмших эрхтэй болжээ. Эргэн тойрны бэлчээрийн газар нь албан ёсны эзэмшилд багтдаггүй ч, ёс заншил нь айл өрхүүд өвөлжөөний бэлчээрээ зун, намар нүүдэллэж ирэх малчдаас хамгаалах эрх олгодог.

Хээрийн судалгаа хийх эхний айл маань намрын эхэнд өвөлжөөний бэлчээрээ хамгаалах оролдлого хийж байхыг би харсан. Тэр айл сүүлийн үед ахиухан бороо хуртай таарсан газар нутаглаж байсан цөөн тооны айлуудын нэг бөгөөд ган гачигт нэрвэгдсэн тухайн бүс нутгийн олон арван гэр бүл тэдний ойр хавьд буухыг хүсч байлаа. Манай гэр бүл өвлийн бэлчээрээсээ хэдэн километрийн зайд малтайгаа буусан бөгөөд өвөлжөөгөө цаг ямагт эргэж нөхцөл байдлыг хянаж, хэрвээ хүмүүс тэнд буусан бол явахыг шаарддаг байлаа. Миний

гэрчилсэн тэдний яриагаар бол, тэнд буусан хүмүүстэй мэндэлсний дараа манай гэр бүлийнхэн тэднийг нүүхийг шаардахад тэд “маргааш нүүнэ”, эсвэл “хэдэн хоногийн дараа нүүнэ” гэдэг байсан ч тэдгээр “амлалт” нь ихэнхдээ хоосон байдаг байлаа. Үнэндээ тэнд буусан хүмүүсээс ярилцлага авахад тэд удахгүй нүүнэ гэж хэлээд буух нь тэнд байхаар зөвшөөрөгдсөн хугацаанаас илүү байх тэдний стратеги гэсэн юм. Тэд малчдад ч, засаг захиргааны ажилтнуудад ч адилхан худал хэлдэг байна. Эрсдэлийн менежментийн үүднээс авч үзвэл аль аль талын нөхцөл байдлыг ойлгоход амархан. Хүнд хэцүү өвлийг даван туулахад “зөвшөөрөлгүй буусан” хүмүүс мал сүргээ таргалуулахын тулд тохиромжтой зуны ба намрын бэлчээрт буух эрхтэй бөгөөд ихэнх тохиолдолд боломжийн бэлчээрийн газар нь бусдын өмчийн өвөлжөө байдаг. Нөгөөтэйгүүр, малчид өвөлжөө бэлчээрээ бусдаас хамгаалах ёстой бөгөөд тэгэхгүй бол мал сүргээ өвөл аюул заналхийлэлд учруулна гэсэн үг.

Миний хамт амьдарч байсан гэр бүл зөвшөөрөлгүй буусан хүмүүсийг хөөхийн тулд өвөлжөөндөө түр буудаг байсан ч энэ нь хэцүү ажил байлаа. Настай эсвэл чинээлэг малчид залуу эсвэл ядуу малчдыг бодвол давуу тал ихтэй байдаг учраас өвөлжөө бэлчээрээ хамгаалах буюу бусад бэлчээрт нүүх чадвар нь малчин өрх бүрийн хувьд өөр өөр байдаг бололтой.

Нэмэлт хөдөлмөр эрхлэх: Зарим малчин өрхүүд хамаатан садан болон танил талаа тэдэнтэй хамт амьдруулж, ихэнхдээ цалин хөлсгүйгээр мал маллах болон бусад ажлаа хийхэд туслуулдаг. Энэ нэмэлт хүн хүч нь хүнд хэцүү өвлийг даван туулах, өвөлд бэлтгэхэд маш чухал зүйл болдог.

Төслийн дэмжлэг авах: Зарим малчид хөгжлийн төслүүдээс эрсдэлийн менежментийн дэмжлэг авах боломжтой байдаг. Одоогийн байдлаар, бүлэг гэр бүлийнхэн бэлчээрийн жижиг хэсгийг тойруулж хашаа барьснаар зуд нүүрлэх үед мал оруулах боломжтой болгох үйл ажиллагааг дэмжих төсөл уг газар хэрэгжиж байна.

Үржүүлгийн хязгаарлалт: Малчид үргэлж малын тоо толгойг өсгөхөд хэтэрхий их анхаарал тавьдаг, мал сүргийн чанарт анхаарал хандуулдаггүй гэсэн шүүмжлэл байдаг. Гэвч энэ сумын хувьд олон малтай хүмүүс шагнал авдаг хэдий ч хэдхэн малчин л мянгаас илүү малтай байна. Малчид бүх чадлаараа малын тоо толгойгоо өсгөх гэсэн хандлага энд байхгүй бололтой. 2010 оны зудын үеэр ч гэсэн энэ сумын малчид малын чанарт илүү анхааран тоо толгойг золиосолсон байна. Зун хур багатай, өвлийн бэлчээр муу байсан учир тэд намар аль хэдийнэ хүнд өвөл болно гэдгийг урьдаас мэдэж байсан юм. Тийм учраас малчид “ухна тавихгүй” гэж шийдсэн байжээ. Өөрөөр хэлбэл, ямаа үржүүлэхийг хязгаарлана гэсэн үг. Хүнд хэцүү өвөл хээлтэй ямаа хорогдох магадлал өндөр, эсвэл үр төл нь зулбах бөгөөд хүнд өвлийн хавар төрсөн ишиг амьд гарах нь ховор байдаг байна. Энэ сумын бараг бүх малчид 2009 онд ухна тавихгүй гэж шийдээд зөвхөн цөөн тооны тарган эм ямаан дээр тавихаар шийдсэн нь ямаан сүргийн дийлэнх нь өвөл, хаврыг өнтэй давж туулах боломжтой болж байгаа юм. Тэд 2010 оны турш малын өсөлт болон сүү цагаан идээгээ золиосонд гаргасан, учир нь хавар нь цөөн мал төллөж, зун намар саах мал цөөхөн байсан байна.

Даатгал: Социализмын үед малын даатгалын төлбөрийг автоматаар малчдын цалингаас суутгадаг байсан (Темплер болон бусад, 1993 он). Малын даатгалын тогтолцоо 2006 онд Баянхонгор аймагт, бусад аймгуудад дараах он жилүүдэд дахин нэвтэрсэн байна. Энэ нь эрсдэлийг удирдан хянахад оновчтой сонголт боловч малчид 7-р сарын дунд гэхэд даатгалын төлбөрөө хийх ёстой гэж заасан нь сумын төвөөс хол нүүдэллэж байгаа малчдад хүндрэлтэй гэх мэт саад бэрхшээл их байгаа юм. 2010 оны зудаас өмнө малаа даатгуулсан (хямд өртгөөр даатгуулсан) зарим өрх бүл даатгалын нөхөн төлбөрт алдсан малаа нөхөхөд ч хүрэхгүй төлбөр авсан нь зарим малчдыг даатгал авмааргүй бодолд хүргэсэн байна.

Малчдын амжилт болон эмзэг байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Социализмаас капитализмд шилжих үе нь ихэнхдээ баян, хоосны ялгааг бий болгодог (Буравой ба Вердери 1999 он). Энэ нь Монгол мал аж ахуйд тохиолдсон жишээ юм. Шилжилтийн дараа гарч ирсэн “шинэ ядуучууд” нь үнэндээ социализмын үед өөр салбарт ажиллаж байсан шинэ малчид юм. Туршлагагүй учир эдгээр малчид зудын үед уян хатан байж чадахгүйгээр барахгүй, ганц хоёр зудаар малаа алдсанаас хойш урам хугаран мал маллахаа больдог байна (Жанзен, 2005 он). Үнэндээ малчид туршлага бол зудыг даван туулахад хамгийн чухал зүйл гэж үздэг.

Санал асуулгаар зудын үед хэрхэн уян хатан байх вэ гэдэг талаар малчдын төлөв байдлыг судлаад мөн доорх чиглэлээр судалж үзэхийг оролдлоо:

1. Хэдий хэмжээнд байхад нь малчид зудыг удирдан хянаж, тогтоож болдог зүйл гэж үздэг талаар;
2. Зудад уян хатан хандах, эсвэл эмзэг байхад нөлөөлөх хүчин зүйлс;
3. Залхуу, хариуцлагагүй байх нь дээрх хүчин зүйлст багтана гэж малчид боддог эсэх; эсвэл
4. Малын их хэмжээний хорогдол нь заримдаа яахаас ч өөр аргагүй байдалд орсон байсан эсвэл азгүйгээс болсон гэж үздэг эсэх талаар асуулаа.

Дараах асуултуудаар зудыг даван туулахад юу нь чухал вэ гэдгийг тодруулахаар малчдаас асуусан. Оролцогчдын хариултын хувийг хүснэгтийн баруун гар талын баганад бичсэн байгаа (нийт 83 хүнээс асуусан)

Зудыг амжилттай давахад юу хамгийн их хамааралтай вэ? (гурвыг сонгоно)		
а.	Амьдралын буюу эдийн засгийн боломж	29%
б.	Ажилсаг байдал	79%
в.	Хүн хүчний байдал(ам бүл, тэдний ажиллах чадвар)	40%
г.	Туршлага	54%
д.	Бэлчээр, газрын гарц	65%
е.	Аз	5%

Сонирхолтой нь оролцогчдын хамгийн их сонгосон хоёр сонголтын нэг нь ажилсаг байдал бөгөөд энэ нь малчдын өөрсдийн хяналтан дор байдаг зүйл байхад нөгөө нь бэлчээрийн чанар гэсэн нь малчдын хэр мэдлээс давсан зүйл юм (Бэлчээрийн чанар нөөцлөлт, нүүдлийн сонголтоос ихээхэн хамаардаг ч, энэ сумын ихэнх малчид цаг агаар хамгийн их нөлөөлдөг гэж үздэг). Шаргуу ажилсаг байдалд малчид ач холбогдол өгч байхад тэднийг залхуу хэмээн буруушаах нь гайхалтай хэрэг. Туршлага мөн дээгүүр дүнтэй гарсан байна. Ихэнх оролцогчид чухал бус гэж үзсэн нь аз байлаа. Үнэндээ зарим малчид азаар малын хорогдолгүй зудыг даван туулж болох юм гэж асуухад инээж байсан юм. Энэ нь малчид зудын үр дагаварт чухал хариуцлага оноож байгааг харуулж байгаа юм. Орон нутгийн малчдаас азын тухай цааш нь дэлгэрэнгүй асуухад эдийн засаг хувьсамтгай, баталгаагүй учир бизнест аз тодорхой хэмжээгээр үүрэг гүйцэтгэх боловч, мал маллагаанд төдийлөн чухал биш гэж хариулсан.

Дараах асуулт дээрх санааг цааш нь лавшруулж зудыг амжилттай давж чадаагүй малчин өрх бүлийн тухай асуугаад яагаад гэдэгт тайлбар авсан юм.

Өнгөрсөн жилд эсвэл 2011 онд бүх малаа зуданд алдсан малчин өрхийг та мэдэх үү? Тэд малаа алдах гол шалтгаан нь юу байсан бэ? (олныг сонгож болно)		
а.	Туршлагагүй	41%
б.	Залхуу	28%
в.	Боломжгүй (санхүүгийн хувьд)	24%
г.	Хүн хүч дутагдалтай	27%
д.	Архичин	6%
е.	Хариуцлагагүй	28%
ё.	Эрсдэлийг ойшоогоогүй	21%
ж.	Идэшгүй газарт өвөлжсөн	49%
з.	Азгүй	11%

Өмнөх асуултад хариулсан оролцогчид ажилсаг байдал, туршлага болон бэлчээрийн чанар нь зудыг эсэн мэнд даван туулахад хамгийн чухал хүчин зүйл гэж хариулсныг авч үзвэл, зуданд нэрвэгдсэн өрх бүлийн хамгийн том дутагдал нь залхуу, туршлагагүй байх болон бэлчээрийн чанар муу гэсэн дүгнэлтэнд хүрч болох юм. Гэвч туршлагагүй байх, бэлчээрийн чанар гэсэн хоёр хариулт их давтагдан дурдагдсан бол залхуу байх гэсэн хариулт цөөхөн байлаа. Ихэнх малчид тэд болон бусад малчид эрсдэлийг даван туулах гэж чадах чинээгээрээ хичээж байгаа гэж боддог. Болдогсон бол тэд намар илүү их хадлан өвс нөөцөлж авмаар байвч тус нутаг дэвсгэрт байгалаасаа ургах хадлан өвс байхгүй бөгөөд ялангуяа ган гачиг их жилд улам бага байна.

Улам гүнзгийрүүлж тодруулахын тулд малчдаас тэд өөрсдийгөө болон бусад малчдаа залхуу гэж боддог эсэхийг асуулаа:

Зарим хүмүүс, жишээлбэл хотын хүмүүс малчид залхуу тийм учраас тэд зуданд малаа алддаг гэж боддог. Энэ үнэн үү?		
а.	Ихэнх малчид залхуу.	14%
б.	Малчдын цөөн хэд нь залхуу.	54%
в.	Бүх малчид ажилсаг.	32%

Хариултаас үзвэл ихэнх малчид тэдний ихэнх нь эсвэл хэн нь ч залхуу биш гэж боддог нь харагдаж байна. Малчид бүгдээрээ ажилсаг гэж хариулсан хүмүүс тайлбарлахдаа малчид бүх малаа алдаад дуусна, эсвэл өөр ажил олж хийх ёстой болох учраас залхуу хүн бол малчин байж таарахгүй гэжээ. Хэдий тийм боловч энэхүү асуултыг тавих арга хэлбэрийг өөрчилж үзсэний үр дүнд сонирхолтой хэв маяг ажиглагдсан юм. Санал асуулгыг аман хэлбэрээр оролцогч нэг бүрээс тусад нь асуулт асууж явуулсан. “Энэ үнэн үү?” гэж асуухад(өөрөөр хэлбэл, малчид залхуу гэдэг үнэн үү гэсэн асуулт), олон оролцогч тэр даруйдаа “Тийм, үнэн” гэж хариулсан. Гэвч би хариултаудыг уншиж өгөхөд ихэнх нь нухацтай бодож байгаад “б” эсвэл “в” гэсэн хариултыг сонгож байсан. Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл, малчид өөрсдийн олон удаа сонсч байсан ойлголт, яриаг давтдаг боловч тэдний өөрсдийн ажиглалт болон туршлага нь үүнийг тэр болгон батлаад байдаггүй байна.

Зудын эрсдэл болон зуданд мал сүргээ алдах өртөмтгий байдлын тухай юу гэж боддогийг малчдаас асуух санал асуулгын дараагаар 2010 оны зуданд энэ суманд бүх малаа алдсан 20 гаруй өрх бүлээс тэдний энэ азгүй явдалд ямар хүчин зүйлс нөлөөлснийг тодруулахаар ярилцаж үзлээ. Санал асуулгаар тодорхой болсон зуданд өртөмтгий байх хүчин зүйлс хүчинтэй хэвээр байгаа ч, ярилцлагын үр дүнд архаг ядуурал болон хүн хүчний хомсдол нь малчдыг эмзэг байдалд хүргэх хүчин зүйлс гэдэг нь тодорхой болсон. Эдгээр малчин өрхийн ихэнх нь зуд болохоос өмнө 100 хүрэхгүй малтай байсан байна (ихэнх нь хонь, ямаа). Зарим малчин өрхийн чинээлэг хөршүүд хэдэн зуун малтай байж байгаад зуданд нэг хоёр зуун малаа алдаж байхад хэдхэн малтай өрх бүл анхнаасаа цөөн малтай учир зуданд бүх малаа алдах магадлал өндөр байна. Энэ нь хэрвээ малчин өрхүүд сайн чанарын цөөн малтай бол эрсдэлийг давж гарах магадлал өндөр гэсэн өнөөгийн хөгжлийн ойлголтыг эргэлзээтэй болгож байгаа юм.¹²⁹ Үнэндээ, өнгөрсөнд хийгдсэн судалгаагаар бол гамшигт өртөмтгий бүсийн хувьд их малтай байх нь эрдсэлийн менежментэд чухал (Даал ба Хёорт, 1976 он) гэж үздэг боловч Монголын хувьд олон малтай байх нь тодорхой ашиг тустай хэдий ч бэлчээрийн доройтолд ихээхэн сөрөг хувь нэмэр оруулдаг учир тийм ч сайн зүйл бас биш юм.

Мал сүргийн тоогоор харьцангуй ядуу байхын хажуугаар зуданд бүх малаа алдсан айл өрхүүд хүн хүчний хувьд бас сул дорой байсан. Сонирхолтой нь

¹²⁹ Гэвч хамаг юмаа алдсан гэр бүлийн малын чанар нь бусад гэр бүлийн малын чанартай харьцуулахад ямар байхыг би мэдэхгүй.

эдгээр малчин өрхийн хагас нь 50 буюу түүнээс дээш насны хөгшид байсан бөгөөд тэдний нэгээс бусад өрх нь коммунист нийгмийн үед мал маллаж байсан бөгөөд малчин айлын хүүхдүүд байсан асар их туршлагатай хүмүүс байна. Хэрвээ туршлага нь зудын эрсдэлийг даван туулахад хамгийн чухал хүчин зүйл болж байгаа юм бол, яагаад туршлагатай олон малчид энэ эрсдэлийг амжилттай давж чадахгүй байна вэ? Үүнд өгөх нэг хариулт нь хөгшидтэй гэр бүлийн хүн хүч тааруу байгаа нь асуудал болж байгаа юм. Дараах хүснэгтээр мал сүргээ зуданд алдсан гэр бүлүүдийн өөр өөр нөхцөл байдлыг харуулж байгаа бөгөөд гэр бүлийн хөдөлмөрийн чадавхид үзүүлэх үр нөлөө нь илт нийтлэг байгаа нь харагдаж байна.

Зудын үеэр мал хорогдоход хүргэх хүн хүчний хомсдол	
а.	Хөгшидтэй гэр бүл ¹³⁰
б.	Хүүхэдтэй гэр бүл (0-6 насны хүүхэд): мал маллах хүн хүч саарна ¹³¹
в.	Ганц бие гэр бүл
г.	Архидалтад нэрвэгдсэн гэр бүл
д.	Биемахбодийн буюу сэтгэл санааны хөгжлийн бэрхшээл эсвэл өвчин эмгэгтэй хүнтэй гэр бүл

Жейнз ба Чулуундоржийн (2004:251) үзэж байгаагаар хямралын үед тусламж дэмжлэг үзүүлэх найз нөхөд, хамаатан садан байхгүй гэх мэт нийгмийн хувьд маргинальчлагдсан (нийгмээс гадуурхагдсан) байх нь малчин өрхүүдийг эмзэг байдалд оруулах нэгэн хүчин зүйл болдог. Зудын үеэр бүх малчин өрх малаа эсэн мэнд авч гарахын тулд завгүй ажилладаг учраас энэ үеэр малчин бус найз нөхөд, хамаатан садан нь өвс тэжээл авах мөнгө төгрөг, хөлс хүч болон бусад төрлийн тусламж үйлчилгээгээр хувь нэмэр оруулах нь юунаас ч илүү хэрэгтэй байдаг.

Эрсдэлийг хянах чадвар гэдэг ойлголт

Энэхүү судалгааны нэг зорилго нь малчид хэдий хэмжээнд зудын эрсдэлийг хянаж болдог гэж үздэгийг судлах явдал байлаа. Нийслэл хот Улаанбаатарт амьдардаг Монголчууд болон гадаадынхан зудаас болж мал хорогдох нь малчид эрсдэлийг удирдан хянаж чадаагүйгээс боллоо гэж үзэх нь хувь хүний түвшинд хүртэл зуд бол хянаж болдог зүйл гэсэн утга санаа илэрхийлж байна гэсэн үг. Хувь хүний түвшинд эрсдэлийг хянаж болдог гэж үзэх нь Баруунд нийтлэг үзэл бөгөөд хэдийгээр энэ нь хүчтэй байхыг дэмжиж байгаа мэт боловч гамшгийн хохирогчдыг шударга бусаар буруутгаж байгаа явдал юм. Зарим хүмүүс эрсдэлийг хянаж болдог зүйл гэж ойлгох нь логикийн хувьд ч, түгээмэл

¹³⁰ Монголын хөдөө орон нутагт хүмүүс залуу насандаа Барууныхнаас эрт хөгшин хүнд тооцогддог. Энэ нь магадгүй ахмад насны Монголчуудын дунд өвчлөлт, хөгжлийн бэрхшээл байнга тохиолддог мөн дундаж наслалт нь доогуур буюу 68 байдгаас үүдэлтэй байж болох юм.

¹³¹ Сургуульд орох хүүхдийн нас 8 байснаа 6 болсон учраас малчин өрх бүлийн хувьд нэгэн шинэлэг асуудал гарсан. Эцэг эхчүүд 6 настай хүүхдээ сургуулийн дотуур байр, эсвэл сургуульд сурангаа хамаатныдаа байлгахгаар сумын төв рүү явуулахдаа санаа нь зовдог болсон. Тийм учраас хичээлийн жилийн хугацаанд эхчүүд сумын төвд хүүхдүүдтэйгээ амьдрах болсон нь гэрийн ажил цалгардах болсон. (Хүүхдүүдийг сургууль төгсөхөөс нь өмнө сургууль завсардуулах, эсвэл тэднийг мал дээр гаргах гэж сургуульд явуулахгүй байх нь ховор болжээ, учир нь малчид хүүхдүүдийнхээ боловсролыг эн тэргүүнд тавьдаг болсон байна.)

байдлаар ч үнэн гэж бодож болох авч, өөр өнцгөөс харвал зуд болон бусад гамшгийн хохирогчид аливаа завшааны хохирогч болсон байж болно (энэ нь эрсдэл бол тийм ч их хянаж болдог зүйл биш гэсэн үг). Эсвэл тэд иймэрхүү гамшигтай уламжлалт ёсоор тэмцэхэд шаардлагатай тэдний нөөц баялагийг үгүй болгодог улс төр, эдийн засаг, экологийн хүчин зүйлийн хохирогч болж байгаа юм.

Ярилцлага авах үеэр Говийн бүсийн энэ нутаг дэвсгэрт амьдарч буй малчид зарим нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн улмаас, дийлэнх нь байгал орчны өөрчлөлтийн улмаас гамшгийг даван туулах арга хэрэгслээ алдаж байна гэж боддог гэжээ. Тэдний онцлон тэмдэглэж байгаагаар хуурай цаг уур болон бэлчээрийн доройтол улам ихэсч байгаа ажээ. Бэлчээрийн даацыг хэтрүүлэх нь бэлчээрийн доройтлын гол хүчин зүйл гэдгийг олон эрдэмтэд няцаадаг бол сүүлийн жилүүдэд зуны улиралд хур бороо багатай байгаагаас бэлчээрийн чанар муудаж байна гэж маргах болжээ.¹³² Энэ нь говь хээрийн нутаг дэвсгэр нь бэлчээрээс илүү цаг агаарын нөхцөл байдлаас хамааран жилээс жилд тогтмол бус байдалтай гэсэн үзэл бодолтой санал нийлж байна (Фернандез-Гименез ба Аллен-Диаз, 1999 он). Ган болон бэлчээрийн доройтол нь малчдын хүнд хэцүү өвөл мал сүргээ эсэн мэнд авч үлдэх чадавхид дараах гурван арга замаар нөлөөлдөг: 1) хамгийн сайн бэлчээрийг ашиглахаар байнга зун, намрын улиралд нүүдэллэсэн ч, малчид мал сүргээ тэр болгон сайн таргалуулж чадахгүй байж болох бөгөөд ингэснээр тэд өвөл эмзэг, өртөмтгий байдалд орно. 2) Тухайн нутаг дэвсгэрт мал жилийн турш тэр газраа бэлчих учраас бэлчээрийн доройтол өвлийн улиралд байнга саад бэрхшээл учруулна. 3) Ган гачиг нь малчдын өвөл болон хавар тэжээлд хэрэглэх хадлан өвсний нөөцлөх ажлыг улам хүндрүүлдэг. Зун хур бороо орох эсэх нь хамгийн чухал хүчин зүйл бөгөөд хуурай зун нутгийн хүмүүс “зун болсонгүй” гэдэг. Өвлийн цас, мөс, хүйтэн байх нь угийн гамшиг дагуулдаг боловч энэ бүсийн нутаг дэвсгэрт тохиолдох зудын гол төрөл нь ган зудбөгөөд энэ нь хуурай зун болсны дараа хахир хатуу өвөл болохыг хэлнэ.

Цаг уурын нөхцөл байдаас үүдэлтэй ноцтой саад бэрхшээлийг эс тооцвол, малчид мал хорогдохын цаана байгалийн хүч ба хүний үйл ажиллагааны алдааны хосолсон үр дагаврын нөлөө байна гэж үздэг. Хувь хүний түвшинд малчдын зүгээс зудыг аль хэр хэмжээнд хянаж болдог зүйл вэ гэж боддог эсэхийг олж мэдэхийн тулд дараах санал асуулгыг явуулж үзлээ:

Зудын нөлөө байгалаас хэр их хамаардаг вэ? Малчдын ажлаас хэр их хамаардаг вэ? (нэгийг сонгоно)		
а.	Ихэвчлэн байгалаас хамаардаг. Малчид сайн ажилласан ч байгалийн бэрхшээлээс болж мал их хорогдоно.	34 %
б.	Ихэвчлэн байгалаас хамаардаг, гэхдээ малчдын шаргуу ажиллах нь	

¹³² Бусад малчид бэлчээрийг эрчимтэй ашиглах, ялангуяа ямаа бэлчээрийг таллах нь бэлчээрийн газрыг үгүй хийж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

	үр дүнд ихээхэн нөлөөлнө.	28 %
в.	Ихэвчлэн малчдын ажлаас хамаардаг, гэхдээ байгалийн бэрхшээл их бол малчид мал хорогдох аюулаас зайлсхийх боломжгүй.	16 %
г.	Малчид шаргуу ажилладаг, туршлагатай, бас оновчтой шийдвэр гаргаж чаддаг бол тэд ямар ч хүнд хэцүү байгалийн нөхцөл байдлыг давж гарч чадна.	22 %

Малчдын хариулснаас үзвэл ихэнх малчид зудын үр дагаврын эсрэг тэдний хяналт хязгаарлагдмал гэж боддог байна. Мөн зарим малчид ярилцлагадаа зудын эрсдэлийг говийн бүс нутагт удирдан хянах нь бараг боломжгүй байхад хадлан, өвс тэжээл хурааж, боломжит гамшгийн үед хэрэглэхээр нөөцлөх боломжтой гэдэг утгаараа тал хээрийн бүсэд илүү хянах боломжтой гэдгийг цохон тэмдэглэжээ. Хүнд хэцүү нөхцөл байдалд хүчгүйдэж, мөхөсдөх мэдрэмж төрөх нь юу ч хийсэн амжилтгүй болно гэсэн үг биш юм, учир нь хадлангийн оронд өөр төрлийн өвс тэжээл бэлтгэх, олон аргаар эрсдлийг даван туулах малчдын хүчин чармайлт нь талаар болохгүй.

Эрсдлийг даван туулах хамгийн цөхрөнгөө барсан оролдлого нь өвлийг оторт өнгөрөөх явдал байж болох юм. Нутгийн олон малчин өрх бүл, ялангуяа дундаас их хэмжээний малтай айлууд өөрийн нутагт 2009 оны зуны ган гачиг болж өвлийн бэлчээргүйн улмаас 2009-2010 оны өвлийг өөр сум, тэр бүү хэл өөр аймагт өнгөрөөсөн байна. Эдгээр айл өрхүүд ийм санаачлага гаргаж, алсыг харж чадсан нь сэтгэгдэл төрүүлэм. Гэвч тэдний ихэнх нь нутагтаа үлдсэн хөршүүдээ бодвол илүү олон толгой малаа алдсан байна. Тэдний сонгож буусан газарт тэдний нутгаас илүү их хэмжээний цас орж таарсан байна. Миний тайлбарлаж байгаагаар бол энэ нь азгүй тохиолдол. Хэдийгээр тийм боловч, энэ талаар малчдаас санал асуулга явуулахад ихэнх малчид өөрөөр тайлбарласан юм:

Таны өвлийн бэлчээр чанар нь доройтож муудсан, мөн зуд болж магадгүй гэж бодож байвал та өвөл өөр газар луу нүүж оторлох уу? (нэгийг сонгоно)		
а.	Тэгэх шаардлагатай.	23%
б.	Олон малтай бол оторлосон нь дээр, цөөхөн малтай бол оторлох хэрэггүй.	26%
в.	Ер нь өөрийнхөө нутагт, мал дассан газартаа өвөлжсөн нь дээр. (Хүмүүсийн хэлснээр хонь ямаа дассан газраа сайн идээшдэг.)	50%
г.	Оторлох сайн муу нь хэр азтайгаас хамаардаг. Тэр газрын өвөлжилтийн нөхцлийг мэдэх аргагүй.	1%

Өвөл оторт гарах уу, эсвэл гэртээ үлдэх үү гэдэг дээр оролцогсдын санал зөрөлдөж байгаа боловч тэдний бараг хэн нь ч тухайн эрсдэл хүний азтай азгүйгээс шалтгаалахгүй гэж үзэж байгаа нь нийтлэг үзэл бодол байлаа. Малчид

эрсдэлийг даван туулахын тулд бүх хүчин зүйлийг бодолцон хамгийн ухаалаг шийдвэр гаргаснаар үүрэг хариуцлагаа ухамсарлаж хүлээж авдаг.

Малчдын болон Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлага: Эрсдэлийг тухайн соёлоос шалтгаалан өөр өөрөөр хүлээн авч, хариу үйлдэл үзүүлдэг. Өндөр хөгжилтэй нийгэмд хүртэл хувь хүн, бүлэг хүмүүс болон засгийн газрын хүрээнд эрсдэлийн олон янзын төрлийг удирдан хянахад ямар үүрэг хариуцлага хүлээх нь өөр өөр байдаг. Нөгөөтэйгүүр эрсдэлийн менежментийн хариуцлага нь ёс суртахууны мэтгэлцээний гол сэдэв болж байдаг. Англи хэлний “хариуцлага” гэдэг үг 18-р зуунаас л хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд өөрийн сайн сайхны төлөө хувь хүний хариуцлага гэдэг утгаар илүү хэрэглэгддэг. Харин эрсдэлийг даван туулах гэдэг утгаар хэрэглэгдэх болсон нь Европт орчин үе ба либерализм хөгжих үе бөгөөд капитализмтай холбоотойгоор эдийн засгийн тэгш бус байдлын эсрэг хамгаалалттай байх гэсэн ойлголттой илүү холбогддог (Гидденс 1999 он; Хөршман 1997 он). Эрсдэлийн менежментийн хариуцлагыг хуваарилахад ихэвчлэн хэрэглэгддэг загвар нь илүү цомхон арван жил тутмын хэмжээсээр хэмжигддэг. АНУ-ын жишээг авч үзвэл, эрсдэлийн хуваарилалтын шилжилт нь компани болон засгийн газраас хувь хүнд шилжсэн нео-либерал шилжилтийг ажиглаж болох бөгөөд энэхүү шилжилтийн үр дүн нь 20-р зууны сүүлийн хагаст ажиглагддаг (Хакер, 2006 он).

Монгол улсын хувьд ч ерөнхийдөө хувь хүний хариуцлагыг эн тэргүүнд авч үзэх нь одоогийн нөхцөлд нийтлэг байна. Засгийн газрын архивын баримт бичгээс үзвэл энэ нь бас социализмын үед нийтлэг үзэгдэл байсан. Хэдийгээр тийм боловч тухайн үед хариуцлагыг эдийн засгийн тодорхой агентуудад л шууд хуваарилдаг байсан. Хувь хүмүүс өөрсдийн үүрэг ролийг хариуцлагатай биелүүлэх ёстой байдаг байсан бол, социалист бүтэц нь гамшгаас хамгаалах аюулгүй байдлаар хангадаг байсан учир энэхүү тогтолцоог одоог хүртэл олон Монгол хүн санагалздаг. Малчид тэр үед улсын малыг малладаг байв. Тэд баг бүлэгт хуваагдан, тушаал авч ажиллан, улмаар зудын үеэр өвс тэжээлээр хангагдах зэргээр улсаас дэмжлэг авдаг байлаа. Одоо ч гэсэн олон малчид орон нутгийн засаг захиргаатай ойрхон харьцаатай байхыг эрмэлздэг нь харагдаж байгаа бөгөөд орон нутгийн удирдлагууд сонгогчдод өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд айл өрхийн нөхцөл байдлыг шалгаж, мэдээлэл дамжуулан, мөн тэдний саналыг сонсохоор судалгаа хийсэн суманд очсон байна. Малчид засгийн газар болон орон нутгийн засаг захиргааг зуданд нэрвэгдсэн үед тэдэнд тусалж дэмжээсэй гэж хүсдэг.

Малчдын санал нийлсэн, нийлээгүй доорх санал асуулгын цуврал мэдэгдлээс засгийн газрын гүйцэтгэх ёстой тодорхой үүрэг ролийн талаарх тэдний үзэл бодлыг нь харж болно:

Зудын эрсдэлийн менежментийн хувьд орон нутгийн засаг захиргааны үүрэг ролийн талаарх дараах саналтай та санал нийлж байна уу, эсвэл нийлэхгүй байна уу? (олныг сонгож болно)

а.	Багийн дарга нар намар айлуудаар явж өвлийн бэлтгэлийг шалгах ёстой.	85%
б.	Багийн дарга нар хэдий хэмжээний өвс бэлдэхийг нь хэлж өгөх зэргээр өвлийн бэлтгэлийн талаар малчдад зааварчилгаа өгөх ёстой.	55%
в.	Багийн дарга нар өвлийн бэлтгэлээ сайтар базаагаагүй малчдыг шийтгэх, арга хэмжээ авах ёстой.	33%
г.	Багийн дарга нар нэмэлт өвс тэжээл өгөх зэргээр өвлийн бэлтгэлээ сайтар базаагаагүй малчдад туслах ёстой.	45%

Зудын үед малчдад туслах засгийн газрын үүрэг ролийн талаарх дараах саналтай та санал нийлж байна уу, эсвэл нийлэхгүй байна уу? (олныг сонгож болно)		
а.	Зуд болбол засгийн газар малчид руу тэжээл явуулах ёстой.	82%
б.	Засгийн газар зуданд малаа алдсан айлуудад мөнгө өгөх ёстой.	45%
в.	Засгийн газар малчдад ямар нэгэн тусламж үзүүлэх ёсгүй, учир нь малчид өөрсдөө хариуцлагатай байх ёстой.	33%

Эдгээр асуултуудын хариултаас үзвэл, ихэнх малчид орон нутгийн засаг захиргаа болон улс гамшгийн үед өвлийн бэлтгэлд хариуцлагатай хандаж, малчдад туслах ёстой гэж үздэг байна. Хоёрдугаар асуулт асуухад зөрчилдөөн гарсан байна: зарим оролцогчид “а” ба/буюу “б”-г сонгосны дээр бас “в”-г сонгосон байна. Яагаад гэвэл малчид өөрсдөө хариуцлагатай байх ёстой гэсэн “в”-гийн сүүлийн хэсэгтэй санал нийлж байгаа бөгөөд энэхүү мэдэгдлийн эхний хэсгийг анзаараагүй бололтой.

Гадны ажиглагчдын малчид гамшгийн үеэр тусламж хүсдэг гэдэг ойлголт нь ул суурьтай юм. Гэвч ажиглалт, ярилцлага ба санал асуулгын хариултаудын үр дүнд, малчид зудын эрсдэлийг өөрсдийн хүчээр даван туулахын тулд хариуцлагатай ханддаг нь харагдаж байна. Тэд ердөө л засгийн газар санаа тавьж, гар бие оролцох ёстой гэж боддог. 1993 онд Темплер болон бусад эрдэмтэд, харилцан хувьсах эрсдэлийн (нэг цаг үед тухайн газар нутгийн бүх хүнд нөлөөлөх эрсдэл, тухайлбал зуд) үед орон нутгийн нийгмийн аюулгүй байдлын сүлжээ, тэдний үйл ажиллагаа сайн хэрэгжихгүй бөгөөд засгийн газрын зүгээс үзүүлэх тусламж дэмжлэг шаардлагатай гэж үзжээ. Жейнз ба Чулуундорж (2004 он) мөн зудын эрсдэлийг даван туулахад улсын оролцоо хэрэгтэй гэж үзсэн байна. Монголын нийгэм нэг талаар засгийн газар нь зуд болох үед үндэсний мал аж ахуйн салбарт тусламж үзүүлж хамгаалах ёстой гэж үзэх үзэл, нөгөөтэйгүүр эрсдэлийг хувьчлах ёстой, тухайлбал малчдад хувийн даатгалыг санал болгох гэсэн хоёр үзлийн хооронд хуваагдсан бололтой. Азаар засгийн

газар онцгой байдалд эрсдэлийг даван туулах, малчдад туслах наад захын хүчин чармайлт гаргаж байна. Жишээлбэл, засгийн газар аймгуудаар тархсан хадлангийн өвсний фонд үүсгэж, зудын үеэр хямд үнээр зарах арга хэмжээ авч байна. Сум, аймгийн засаг захиргаа, олон нийт малчдыг дэмжих, гамшгийн үр нөлөөг сайжруулах үүрэг даалгавар авч ажилладаг. Тухайлбал, судалгаа хийсэн суманд 2010 оны намар, сумын төвийн бүх "байгууллагууд" (сургууль, банкууд, орон нутгийн засаг захиргаа, гэх мэт.) малчдын өвлийн онцгой байдлын хэрэгцээнд зориулж хуваарилахаар зоодойн нөөцийг бэлтгэх ажилд дайчлагдсан байна. Байгууллага бүрийн гишүүд өөрсдийн байгууллагын квотын шаардлага хангахуйц тодорхой дугаарын зоодой бэлтгэсэн. Иймэрхүү үйл ажиллагаа явуулахад зарим хүмүүсийн тээршаасан бувтнаан сонсогдох хэдий ч, орон нутгийн засаг захиргаа болон сургууль гэх мэт хүндэтгүүштэй газраас тушаал, зарлиг ирэх үед ихэнх Монголчууд иймэрхүү ажлыг уриалгахан хүлээн авч дуртайяа гүйцэтгэдэг. Монголын нийгэм дахь коммунизмын үлдэгдэл нөлөөг Барууныхан шүүмжилж хүлээж авдаг боловч ихэнхдээ ач тустай зарим нэгэн элементийг бид ялгаж салгаж ойлгох хэрэгтэй.

Хэлэлцүүлэг: Энэхүү судалгаа нь хотод ихэвчлэн сонсогддог малчдын эрсдэлийн менежментийн талаарх таагүй дүрслэлд хариу үзүүлэхүйц зарим тодорхой дүгнэлтүүдийг гаргаж байна. Судалгаа хийсэн нутаг дэвсгэрт амьдарч буй ихэнх малчид шүүмжлэгчдийн олж хараагүй янз бүрийн олон стратегийг ашиглан эрсдэлийг даван туулахын тулд уйгагүй ажиллаж хөдөлмөрлөж байна. Миний ярилцсан зарим малчид бизнес сайн хийдэг юм. Тэд зах зээлийн нөхцлийг байнга ажиглаж байдаг ухаалаг бизнес хүмүүс бөгөөд гамшиг нүүрлэхэд малын тоо толгойноос илүү чанарт санаа тавьдаг хүмүүс. Эндхийн малчид засгийн газраас тусламж дэмжлэг, хяналт анхаарал тавихыг хүсч байгаа хэдий боловч, энэ нь тэд өөрсдийн хариуцлагаа умартаж байгаа гэсэн үг биш. Чухамдаа, миний ярилцсан малчид тэдний тухай шүүмжлэлийг хүлээн зөвшөөрч цаашид эрсдэлийг өөрсдийн хүчээр даван туулахын тулд их хариуцлагатай хандах нь зүйтэй гэдэгтэй санал нийлж байлаа. Тэд эрсдэлийг хянаж болдог зүйл гэж үзээд зудын нөлөөг азтай холбоотой гэж хэлэхэд инээлдэж байсан юм. Нөгөө талаар, тэд говийн бүсийн байгал орчны хатуу нөхцөл байдлын улмаас заримдаа малын асар их хорогдолгүйгээр зудыг даван туулах нь боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Малчдын болон засгийн газрын зудын эсрэг хийсэн амжилтгүй үйл ажиллагаанд ихээхэн анхаарал хандуулсаар иржээ. Тухайлбал, Стернберг (2010 он) үзэхдээ 2010 онд болсон зуданд Монголын малын нийт 20% нь хорогдсон нь асар их эмзэг байдлыг харуулж байна гэжээ. Тодорхой газар нутагт ихэнх мал сүрэг хорогдож, олон айл өрхүүд эдийн засгийн хувьд хямрал үзэхэд гамшиг ноцтой байсан нь эргэлзээгүй. Зуд эмгэнэлтэй байсан хэдий ч засгийн газар болон гамшигтай тэмцэх байгууллагуудын тусламжтайгаар малчидхүнд хэцүү нөхцөл байдлаас олон малаа хамгаалж чадсаныг бодолцож үзэх ёстой. Тэдний шаргуу, уйгагүй хөдөлмөргүйгээр хорогдлын хэмжээ улам их гарах байсан. Шүүмжлэгчид гамшгийг даван туулахын төлөө яагаад малчид болон

засгийн газар “юу ч хийгээгүйг” мэдэхийг хүсч байна. Жирийн өвөл, хаврын улиралд ч мал сүргийг арчлах арга хэмжээ, ажиллагааг нүдээр харсан хүний хувьд 2010 оны зудын үед болон түүнээс өмнө малчид маш их завгүй ажиллаж байсан байх. Мөн засгийн газар ч юу ч хийлгүй суугаагүй байсан нь лавтай.

Зудын асуудалд санаа тавьдаг Мөнгөлчүүд болон бусад хүмүүс энэ талаар юу хийх ёстой талаар миний судалгаа ямар үр дүнд хүрч байгааг үргэлж асуудаг. Гэвч миний үзэж байгаагаар энэ судалгаа нь том хүчин чармайлтын нэгээхэн хэсэг төдий бөгөөд асуудлыг ойлгож, бодлогыг мэдээлэх зорилготой. Малчдын үзэл бодлыг тусгаснаар нео-либерал буюу Барууны үзэлтэй хүмүүсийн уг асуудлын хувьд зогсч буй байр суурийг тэнцвэржүүлэхийг зорьсон юм. Надад хэдэн ерөнхий зөвлөмж бий.

Харамсалтай нь зудыг даван туулахад малчдыг эмзэг байдалд оруулж буй асуудал нь тэднийг залхуу хойрго, тусламжинд найдамтгай гэж үздэг ойлголт юм. Энэхүү тогтмол давтагддаг яриа, хэвшсэн ойлголт нь гамшгийн болон хөгжлийн агуулгын хүрээнд аюултай, учир нь тэд асуудлыг “тайлбарлах” үедээ эсрэг нотолгоог үгүйсгэж чадаж байгаа хэдий боловч яг нэг цаг үед шийдэл гаргаж байгаа нь оновчгүй байх талтай (Адгер болон бусад, 2001 он). Зудын эрсдэлийн менежментийг тойрсон бодлогын хэлэлцүүлэг нь хэвшмэл ойлголт болон таамаглалаас илүүтэйгээр бодит ажиглалт, судалгааны ололт дээр тулгуурлан хөл нийлүүлэх ёстой.

Нөгөө талаар хөгжлийн чиглэлээр ажилладаг ажилчид малчдыг шүүмжлэх, эсвэл засгийн газрыг шүүмжлэн малчдад тусламж үзүүлэхээр зорьж байж болох авч, эрсдэлийн менежментийг малчид, засгийн газрын хамтын үйл явцаар биелүүлэх ажил гэж ойлгох хэрэгтэй болов уу. Энэ нь тодорхой хэмжээгээр биелэлээ олж байгаа бөгөөд энэ нь малчдын хувьд таатай сонголт юм. Засгийн газрыг анхаарал хяналт тавьж, тусламж үзүүлэхийг хүсэн хүлээж байгааг малчид үүрэг хариуцлагаа биелүүлж чадахгүй байна гэж ойлгож болохгүй. Засгийн газрын оролцоог ингэж нео-либерал өнцгөөс тайлбарлах нь, миний үзэж байгаагаар, цорын ганц эсвэл шилдэг загвар биш юм.

Key words: herding, зуд, risk management, responsibility, governance

ABSTRACT

This paper interrogates discourses critiquing Mongolian herders' “laziness” and “irresponsibility” in relation to winter risk. Twenty years after the transition from socialism to capitalism, many international development professionals and urban Mongolians feel that herders have been spoiled by state assistance. This paper challenges argues that herders take responsibility for their own herds to the extent possible given the current climate and availability of resources. It outlines several of herders' strategies for mitigating the risk of зуд disasters and discusses herders' views on issues of risk and responsibility. While it is true that most herders still expect state support during severe winters, they perceive the support as a necessary complement to, rather than as a substitute for, rigorous individual efforts to manage risk. While “slackers” exist in every sphere of society, most herders that participated in the research place as much emphasis on individual responsibility as their critics.

НОМ ЗҮЙ

1. Адгер, ВН, Тор А Бенжаминсэн, Катрина Браун, ба Ханне Сварсад 2001 он Дэлхийн байгал орчны ойлголтын улс төрийн экологийг дээшлүүлэх нь: Хөгжил ба Өөрчлөлт 32(4): 681-715.
2. Буравой, Майкл, ба Катерин Вердери 1999 он Тодорхой бус шилжилт: Пост Социалист ертөнцийн өөрчлөлт дахь угсаатны зүй. Ланхам: Роуман ба Литлфийлд.
3. Даал, Гүдрүн ба Андерс Хёорт 1976 он Малтай байх нь: Бэлчээрийн мал аж ахуйн өсөлт ба Өрх бүлийн эдийн засаг. Стокольм: Стокольмын их сургууль.
4. Фернандез-Гименез, Мария Е. баБарбараАллен-Диаз 1999 он Монгол дахь хээр талын ургамлын динамикийн тэнцвэрт бус загварыг турших нь Хэрэглээний зоологийн сэтгүүл 36(6):871-885.
5. Гидденс, Антони 1999 он Эрсдэл ба Хариуцлага. Орчин үеийн хуулийн хураангуй62(1):1-10.
6. Хакер, ЖейкобС. 2006 он Агуу эрсдэлийн шилжилт: Америк ажил, гэр бүл, эрүү мэндийн халамж ба тэтгэвэрийн довтолгоо ба түүний эсрэг хэрхэн тэмцэх вэ? Оксфорд: Оксфордын их сургуулийн хэвлэл.
7. Хөршман, Алберт О.1997 он [1977] Дур ба сонирхол20-р хэвлэл Принстон: Принстоны их сургуулийн хэвлэл.
8. Жейнс, КрейгР, ба Чулуундоржийн Оюунцэцэг 2004 он Чөлөөт зах зээл ба нас барсан эхчүүд: Социализмын дараах Монголд эхчүүдийн эндэгдэл дахт нийгмийн экологи. Анагаах ухааны Антропологийн улирлын дугаар18(2): 230-257.
9. Жанзен, Ёорг 2005 он Монголын хөдөлгөөнт мал аж ахуй: Өнөөгийн асуудал, орон зайн бүтэц, хөдөлгөөнт ба зогсонги хүн амийн бүлгийн хоорондох харилцаа, бэлчээрийн хөгжлийн төлөв байдал. Сенри угсаатан судлал 69:69-97.
10. Миернс, Робин 1996 он Олон нийт, хамтын хүч ба нийтийн бэлчээр: Социализмын дараах Монгол. Хөгжлийн судалгааны сэтгүүл 32:297-339.
11. Сиуруа, Ханна ба Жереми Свивт 2002 он Монголын мал аж ахуйн эдийн засаг дахь ган, зуд ба хараахан өлсгөлөн үгүйХөгжил судлалын институтын сэтгүүл 33(4):88-97.
12. Стернберг, Трой 2010 он. 2010 оны Монголын аймшигт өвлийн гамшиг,Нүүдэлчид 14(1):72-86.
13. Темплер, Гаи,Жереми Свивтба Полли Пеин 1993 он Монголын бэлчээрийн эдийн засаг дахь эрсдэлийн өөрчлөн хувьсахын ач холбогдол, Нүүдэлчид 33:105-122.